



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/308
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2017\0223\AG14.Docx

УХА0122

075332



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл х
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга: Ц.Наранчимэг
Утас: 261663

Цахим хаяг:
naranchimegtse@audit.gov.mn

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:
sambuunyamyamya@audit.gov.mn

Аудитор:
Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг:
serjmyadagb@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар, ЗГ-ын 4-р байр

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Өлзийт Экаунт Аудит ХХК

Утас: 70130460

Цахим хаяг:
auditulziit@gmail.com

Чингэлтэй дүүрэг 6-р хороо

Бумцэндийн гудамж 65-р байр

1. Агуулга
2. Аудитын гэрчилгээ
3. Менежментийн захидал
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭГ. АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур, зүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
11. Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд
 - 11.1 Авлагын бүртгэлийн талаар
 - 11.2 Бараа материалын бүртгэлийн талаар
12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Зөрчилгүй санал, дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1 Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ-2017/300/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн үрээр д Аудитын олон улсын стандартын зарчмуудад үүийн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, үүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 21 өдрөөс 2017 оны 2 дугаар сарын 17 өдрийн хооронд хийхээр төлөвлөн “Өлзийт экаунт аудит” ХХК-ны аудитын баг хэрэгжүүлэв.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв 2016 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Өлзийт экаунт аудит ХХК аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 23 өдрөөс 2017 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Цус сэлбэлт судлалын үндэсний төв-ийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, болон “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Эрүүл мэндийн тухай”, “Эрүүл мэндийн даатгалын тухай”, “Донорын тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Цус сэлбэлт судлалын үндэсний төв эрүүл мэндийн салбарын бодлого, эрх зүйн хүрээнд хүн ардын эрүүл энхийн манаанд бүх хүч нөөцөө дайчлан ажиллаж байна.

Тус эмнэлгийг чмүрэг, үйл ажиллагаа тогтвортой бөгөөд УБ хотын нийт эмнэлгүүдийг эмчилгээний өндөр идэвхи бүхий аюулгүй цус цусны бүтээгдэхүүнээр хангаж улсын хэмжээнд цусны албаны бодлогыг хэрэгжүүл дэг нарийн мэргэжлийн үндэсний төв юм.

Үйл ажиллагааны удирдлага, төлөвлөлт, хяналт, үнэлгээг тус эмнэлгийн ерөнхий захирал хариуцан хэрэгжүүлж байна.

Тус төв нь дараах чиг үүргийн дагуу үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Донорын сургалт сурталчилгаа явуулах.
2. Донороос суурин болон явуулын хэлбэрээр цус цуглуулах.
3. Донороос цуглуулсан цусанд халдвар илрүүлэх шинжилгээ хийх.
4. Цус цусны бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
5. Хадгалах, түгээх /борлуулах/
6. Сургалт явуулах

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь 2016 онд нийт 25,3 мянган донороос 10 000 литр цус цуглуулж УБ хотын эмнэлгүүдэд 10 700 литр буюу 1,063,800.0 мянган төгрөгийн цус, сийвэн бүтээгдэхүүн, хөдөө орон нутгийн цусны станцуудад 83,200.0 мянган төгрөгийн цусны хүүдий борлуулсан байна. Тус төв нь 2016 онд Баянгол ЦЦТөвийг нээн ажиллуулсан бол энэ онд Азийн Хөгжлийн банк Глобал сангийн санхүүжилтээр олон улсын жишигт нийцсэн шинэ барилга ашиглалтанд хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-ын дагуу “Төсвийн бусад байгууллагын дарга захирал эрхлэгч тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Н.Эрдэнэбаяр Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны төсвийг Эрүүл мэнд, спортын яамны төрийн сангаас олгожээ.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Донорын тухай хууль, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж илчилгээний тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны талаар өмнөх аудит болон төлөвлөлтийн шатанд судалсан.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын үнээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа./ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг олж, зарим үйлгээ ихтэй томоохон дансад үүсгэж байсан байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 14-г гүйцэтгэв.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан өөрийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн ACCOULOS програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дотоод хяналтын системийг эрсдэл бага гэж тооцсон болно.

Эрсдэлийг бага гэж тодорхойлсон үндэслэл нь төлөвлөлтийн шатанд авсан шалгах хуудас, санал асуулгын үнд үндэслэсэн бөгөөд дотоод хяналтын гол анхаарах асуудал нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн ажилтнуудын ажлын ач аалал, ур чадвар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь өөрийн үйл ажиллагаанд нь хэр нийцтэй эсэхийг магадлах явдал байв.

6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардалын дүнг сонгов.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Тус эмнэлгийн 2016 оны сандхйн үр дүнгийн тайлангийн нийт зардалын дүн 4,772,755.7 мянган өгрөг бөгөөд түүний 0,5 хувь 23,863.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Бусад үүлэлтээр сонгоход материалын түвшин өндөр гарч байгаа тул сонгосонгүй.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу өрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавиж ажилласан байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны орлогын төлөвлөгөөний биелэлтийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт

/Мянган төгрөгөөр/

Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө сарьцуулснаар
Улсын төсвийн санхүүжилт	3,407,451.9	3,407,451.9	0.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,357,390.0	1,308,225.8	-49,164.2
НИЙТ	4,764,841.9	4,715,677.7	-49,164.2

Батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс 3,407,451.9 мянган төгрөгийн санхүүжилтээ бүрэн авсан боловч үндсэн үйл ажиллагааны орлого 49,164.2 мянган төгрөгөөр тасарчээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасарсан нь эмнэлгүүдээс ирэх цусны захиалга буурсантай холбоотой юм байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр үзүүлэв.

/Мянган төгрөгөөр/

Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт + Хэтрэлт -
Цалин хөлс, нэмэгдэл, НДШ	730,068.6	676,296.3	53,772.4
Тогтмол зардал	207,599.4	63,388.7	144,210.6
Донорын зардал	95,000.0	102,297.0	-7,927.0
Эм, эмнэлгийн хэрэгсэл	3,601,478.4	3,602,632.9	-1,154.5
Бусад зардал	134,615.5	135,350.6	-735.1
НИЙТ	4,768,761.9	4,579,965.5	188,166.4

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хавсралтаар үзүүлэв.

Тайлант онд нийт 24,283.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт хийгдэж бичиг хэрэг, болон донорын сургалтын зардалыг санхүүжүүлж 5,375.7 мянган төгрөгийг буцаан татан төвлөрүүлсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Энэ ажлын үрээнд байгууллагын төсөв, хагас, бүтэн жилийн баталгаажсан санхүүгийн тайлан баланс, аудитын дүгнэлт, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, төлбөрт үйлчилгээний үнэ тариф, журам зааварыг нээлттэй ил тодоор мэдээлж ирсэн байна.

Мөн тухайн тайлант оны худалдан авах төлөвлөгөө нь олон нийтийн хэрэгсэлээр ил тод мэдээлсэн байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Горим сорил хэрэгжүүлэхэд явцад бий болсон Санхүүгийн тайланд тусгасан цусны хүүдийн бараа материалын үлдэгдэл нь тооллогын бүртгэлээс 21,948.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан, тайлант хугацаанд авлага бүрэн барагдуулаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэлийг хангахгүй мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага өглөг үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгддэг гэдгийг, түүний бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн дүнтэй дансанд гарсан ажил гүйлгээг, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 90 хувь, нийт зардлын 75 хувийг тус тус эзэлж байна.

11. Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг, болон материаллаг бус тус бүр нэг нэг алдаа илэрсэн байна. Үүнд:

Авлагын бүртгэлийн талаар

Тайлант оны эцэст авлагын дансны үлдэгдэл 42,029.7 мянган төгрөг байгаа нь урьд оноос 28,165.7 мянган төгрөгөөр буурсан боловч үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

тухай хуулийн 6 дугаар үйлийн 4.8 д зааснаар “Төсвийг зохистой удирдаж авлага өглөг үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Авлага барагдуулах төлөвлөгөө гарган, үе шаттай арга хэмжээ авч тайлант хугацаанд авлага үүсгэлгүй ажиллах зөвлөмж өглөө.

Бараа материалын бүртгэлийн талаар

Бараа материалын дансны үлдэгдлийг тодруулга тайлан, журнал, тооллогын бүртгэлтэй тулган шалгах горим сорилыг хэрэгжүүлэх явцад цусны үүдийн тооллогын бүртгэл нь 21,918.5 мянган төгрөгөөр илүү байв. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 12 дугаар зүйлд зааснаар “Хөрөнгө төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайланг гаргахаас өмнө дуусгах” гэсэн заалттай нийцээгүй тооллого хийх хугацаа хоцроож үлдэгдлийг зөрүүтэй тусгасан.

Санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байх батламж мэдэгдэлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Бараа материал дансны эцсийн үлдэгдэлийг тооллогын бүртгэлтэй тулган зөрүүг санхүүгийн байдлын тайлан болон санхүүгийн үр дүнгийн, төсвийн гүйцэтгэлийн тайланд тус бүр өөрчлөлтүүдийг аудитын хугацаанд оруулан залруулсан болно.

Бараа материал дансны тооллого тооцоог цаг тухай бүр хийж хэвших, тухайн бараа материалын хадгалалтын онцлог шинжийг харгалзамжээ цусны хүү дийн зарцуулалтыг тайлагнах горимд өөрчлөлт оруулж нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтанд тусгах.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад тайлангийн алдааг санхүүгийн тайланд залруулсан бөгөөд бусад залруулаагүй алдаа зөрчил байхгүй болно.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тус төв нь 2016 онд Глобал сан болон Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр олон улсын жишигт нийцсэн барилга үлээн авсан бөгөөд дагалдах тусгай зориулалтын тоног өхөөрөмж, тавилга хэрэгсэлийнүнэ ирээгүй, актаар хүлээлцээгүй, үйл ажиллагаандаа ашиглаагүй сав баглаа боодолтойгоо байгаа тул орлого авч бүртгээгүй учир горим сорил хэрэгжүүлээгүй болно.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй өөр асуудал байхгүй.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 асуудал хөндөгдөж нийт 63,950.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэн болно.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2015 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан бөгөөд аудитын байгууллагаас өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн дагуу тодорхой үр дүнд хүрч ажилласан байна.

Зөвлөмжийн биелэлтийг зүйл тус бүрээр энэ тайлангийн хавсралтаар үзүүлэв.

17. Зөрчилгүй санал дүгнэлт

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31 өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан дэдгэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн шударга илэрхийлэгдсэн байна.



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Агуулга

Тэргүүлэх ач холбогдолын дарааллаар жагсаав:

Асуудал 1

Бараа материалын бүртгэлийн талаар

Асуудал 2

Авлагын бүртгэлийн талаар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидлын тайлбар, тодруулга:

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

| Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн эмнэлэгийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1 Бараа материалын бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	---------------------------

Ажиглалт

Бараа материалын дансны цуснуудийн тооллогын үүтгэл нь 21,918.5 мянган төгрөгөөр илүү байсан нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 12 дугаар зүйлд зааснаар өрхөнгө төлбөр тооцооны тооллогыг жилийн үсгийн тайланг гаргахаас өмнө дуусгах” гэсэн заалттай нийцээгүй тооллого хийх хугацаа хоцроож үлдэгдлийг зөрүүтэй тусгасан.

Зөвлөмж

Бараа материал дансны тооллого тооцоог цаг тухай бүр хийж хэвших, тухайн бараа материалын хадгалалтын онцлог шинжийг харгалзан үзэж цусны хүүдийн зарцуулалтыг тайлагнах горимд өөрчлөлт оруулж нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтанд тусгах.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлагналын үнэн зөв илэрхийлсэн байх батламж мэдэгдэл зөрчигдөх.

Үйлчлүүлэгчийн хариу

Цаашид хэрэгжүүлж ажиллана.

Асуудал 2 Авлагын бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
-------------------------------------	---------------------------

Ажиглалт

Тайлант онд 42,029.7 мянган өргөмж авлагын үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 4.8 -д “Төсвийг зохистой удирдаж авлага өглөг үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Хуулийн заалтыг хэрэглэн ажиллах талаар зөвлөмж өгөв.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль хэрэгжихгүй байх, найдваргүй авлага үүсэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Тодорхой өлөвлөгөө гарган, үе шаттай арга хэмжээ авч авлагын дүнг бууруулан ажиллана. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн удирдлага асуудлын бүртгэлд гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
	Мөнгөн хөрөнгө	-	10,100.00
	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	10,100.00
	Төсвийн харилцах		
	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
	Харилцах / арилжааны /		
	Авлага	70,195,346.00	42,029,659.00
	Төлбөрт үйлчилгээний авлага	67,366,819.00	37,759,959.00
	Татаас санхүүжилтийн авлага	2,828,527.00	4,269,700.00
	Байгуулагасс авах авлага		
	НДШ-ийн авлага өглөг		
	Шатахууны карт /Хувь хүнээс /		
	Цалингийн урьдчилгаа		
	Урьдчилж төлсөн төлбөр	9,065,444.00	27,786,092.00
	Урьдчилгаа тооцоо	433,644.00	194,092.00
	Урьдчилж гарсан зардал	8,631,800.00	27,592,000.00
	Бараа материал	1,296,165,709.00	3,993,865,489.00
	Эм	1,295,855,909.00	3,758,909,539.00
	Тусгай зориулалттай материал		234,132,190.00
	Хангамжийн материал	309,800.00	823,760.00
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,375,426,499.00	4,063,691,340.00
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
	Үндсэн хөрөнгө		
	Барилга байгууламж	443,278,813.00	3,811,953,373.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 267,970,872.00	- 275,358,852.00
	Авто тээврийн хэрэгсэл	94,507,000.00	94,507,000.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 50,378,416.00	- 63,135,119.00
	Машин тоног төхөөрөмж	2,460,813,298.00	6,964,472,253.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 1,549,409,273.00	- 1,608,907,639.00
	Тавилга эд хогшил	119,751,087.00	453,133,125.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 79,344,043.00	- 92,469,353.00
	Бусад үндсэн хөрөнгө	5,043,300.00	5,043,300.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 5,043,300.00	- 5,043,300.00
	Программ хангамж	770,000.00	75,008,305.00
	Хуримтлагдсан элэгдэл	- 770,000.00	- 1,922,037.00
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,171,247,594.00	9,357,281,056.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,546,674,093.00	13,420,972,396.00
	Богино хугацаат өр төлбөр		
	Бусад өглөг	-	-
	Урьдчилж орсон орлого	103,413.00	2,654,380.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	103,413.00	2,654,380.00
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	103,413.00	2,654,380.00
	Цэвэр хөрөнгө өмч		
	Засгийн газрын хувь оролцоо	2,751,097,413.00	2,751,097,413.00
	Өмнөх үеийн үр дүн	- 419,965,111.00	- 418,963,777.31
	Тайлант үеийн үр дүн		10,870,746,002.31
	Дахин үнэлгээний зөрүү	215,438,378.00	215,438,378.00
	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,546,570,680.00	13,418,318,016.00
	ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,546,674,093.00	13,420,972,396.00

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,998,363,451.00	15,650,353,999.00
	Улсын төсвөөс санхүүжих	2,212,323,670.00	3,247,456,532.00
	Улсын төсвөөс	2,212,323,670.00	3,407,451,900.00
	Улсын төсөвт татан төвлөрүүлсэн	-	- 159,995,368.00
	Бараа үйлчилгээний нийт орлого	1,417,411,575.00	7,254,081,533.00
	Хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгө		3,368,674,560.00
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс		24,283,150.00
	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан		
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	944,905,600.00	1,169,636,098.00
	Төсвийн урамшуулал	48,866,475.00	
	Үнэ төлбөргүй авсан БМ-ын орлого	423,639,500.00	2,646,635,393.00
	Бусад орлого		44,852,332.00
	Нэмэлт орлого	368,628,206.00	5,148,815,934.00
	Төсөвт татан төвлөрүүлсэн		
	ТБОН өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		5,148,815,934.00
	ЗГ хоорондын гэрээ болон ОУБ аас төсөл	368,628,206.00	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,998,363,451.00	15,650,353,999.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
	АЖИЛЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	650,718,006.00	677,500,027.00
	Цалин хөлс нэмэгдэл урамшил	580,290,016.00	605,281,880.00
	Үндсэн ба нэмэгдэл цалин	424,395,997.00	602,131,880.00
	Хоол унааны хөнгөлөлт	46,892,050.00	
	Үр дүнгийн урамшил	109,001,969.00	3,150,000.00
	Нийгмийн хамгааллын шимтгэл	70,427,990.00	72,218,147.00
	Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	58,822,190.00	42,376,565.00
	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		3,063,185.00
	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		11,904,070.00
	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		2,970,257.00
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	11,605,800.00	11,904,070.00
	Тогтмол зардал	56,938,047.00	63,388,746.00
	Гэрэл цахилгааны зардал	21,543,978.00	29,376,628.00
	Түлш халаалтын зардал	22,619,606.00	21,137,068.00
	Цэвэр бохир усны зардал	12,774,463.00	12,875,050.00
	Хангамж, бараа материалын зардал	38,848,899.00	30,531,671.00
	Бичиг хэргийн материал	2,280,110.00	2,275,377.00
	Тээвэр шатахууны зардал	5,662,321.00	6,202,934.00
	Шуудан холбооны зардал	706,554.00	1,439,567.00
	Ном хэвлэлийн зардал	356,500.00	
	БҮТЭЗүйл	802,000.00	
	Хог устгал цэвэрлэгээ	29,041,414.00	20,613,793.00
	Норматив зардал	3,272,407,953.00	3,569,146,225.69
	Хоол	70,363,637.00	88,188,274.00
	Эм	3,202,044,316.00	3,479,462,951.69
	Зөөлөн эд нормын хувцас авах зардал		1,495,000.00
	Эд хогшил урсгал засварын зардал	7,348,000.00	8,525,923.00
	Багаж техник хэрэгсэл	780,000.00	506,000.00
	Тавилга		1,055,000.00
	Хөдөлмөр хамгааллын зардал		1,280,000.00
	Урсгал засвар	6,568,000.00	5,684,923.00
	Томилолт		1,638,000.00

Дотоод томилолтын зардал		1,638,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ төлбөр	33,875,200.00	25,955,830.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил		
Аудит	1,000,000.00	1,200,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	747,110.00	350,000.00
Тээврийн хэрэгсэлийн татвар	243,300.00	180,600.00
Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	-	80,000.00
Мэдээлэл технолгийн үйлчилгээ	3,072,360.00	2,977,900.00
Харуул хамгаалалтын зардал	7,278,000.00	17,297,330.00
Мэдээлэл сурталчилгааны зардал	21,296,730.00	3,623,000.00
Газрын төлбөр	237,700.00	247,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	223,954,841.31	372,634,054.00
Бусад зардал	31,867,601.31	36,937,344.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	23,832,887.00	97,579.00
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	168,254,353.00	335,599,131.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,356,470.00	30,287,520.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	10,036,770.00	
Тэтгэвэрт гарахад тэтгэмж	6,319,700.00	30,287,520.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,300,447,416.31	4,779,607,996.69
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	- 302,083,965.31	10,870,746,002.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
Бараа материал худалдсаны олз		
Үндсэн хөрөнгө худалдсны олз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Ханшийн зөрүүгийн гарз	-	-
Хөрөнгө худалдсаны гарз	- 183,082,868.33	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	- 183,082,868.33	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	- 485,166,833.64	10,870,746,002.31

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН / 1 /</u>	<u>3,391,498,419.94</u>	<u>4,739,970,965.00</u>
	<u>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО</u>	<u>1,109,838,737.70</u>	<u>1,308,235,915.00</u>
	Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих	1,109,838,737.70	1,308,235,915.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан	-	
	<u>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	<u>2,281,659,682.24</u>	<u>3,431,735,050.00</u>
	<u>Улсын төвлөрсөн төсвөөс</u>	<u>2,212,323,670.00</u>	<u>3,407,451,900.00</u>
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,212,323,670.00	3,407,451,900.00
	<u>Нэмэлт санхүүжилтийн орлого</u>	<u>68,836,012.24</u>	<u>24,283,150.00</u>
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд болсон нэмэлт санхүүжилт	19,969,537.00	24,283,150.00
	Төсвийн урамшуулал	48,866,475.24	-
	<u>Хандив тусламж</u>	<u>500,000.00</u>	<u>-</u>
	Хандив	500,000.00	
	<u>НИЙТ ЗАРЛАГА БА ЗЭЭЛИЙН ДҮН / 2 /</u>	<u>3,423,145,419.94</u>	<u>4,735,818,765.00</u>
	<u>УРСГАЛ ЗАРДАЛ</u>	<u>3,344,871,540.00</u>	<u>4,575,823,397.00</u>
	<u>Ажиллагчидтай холбогдсон зардал</u>	<u>616,986,543.00</u>	<u>676,296,219.00</u>
	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</u>	<u>549,692,643.00</u>	<u>604,123,312.00</u>
	Үндсэн цалин	433,047,593.00	473,376,342.00
	Хоол унааны хөнгөлөлт	48,800,350.00	52,845,866.00
	Урамшуулал	67,844,700.00	77,901,104.00
	<u>Ажил олгогчоос төлөх шимтгэл</u>	<u>67,293,900.00</u>	<u>72,172,907.00</u>
	<u>Бараа үйлчилгээний урсгал зардал</u>	<u>2,727,884,997.00</u>	<u>3,899,527,178.00</u>
	<u>Байр ашиглалттай холбоотой зардал</u>	<u>57,208,647.00</u>	<u>63,388,746.00</u>
	Гэрэл цахилгаан	21,543,978.00	29,376,628.00
	Түлш халаалт	22,890,206.00	21,137,068.00
	Цэвэр бохир ус	12,774,463.00	12,875,050.00
	<u>Хангамж бараа материалын зардал</u>	<u>20,254,085.00</u>	<u>19,387,227.00</u>
	Бичиг хэрэг	789,403.00	1,459,800.00
	Тээвэр шатахуун	5,684,700.00	5,550,900.00
	Шуудан холбоо интернет	706,554.00	1,439,567.00
	Ном хэвлэл	356,500.00	
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгал, ариутгал	11,716,928.00	10,629,960.00
	БҮТЭЗҮйлс	1,000,000.00	307,000.00
	<u>Нормативт зардал</u>	<u>2,528,787,259.00</u>	<u>3,704,850,051.00</u>
	Эм,эмнэлгийн хэрэгсэл	2,434,316,205.00	3,600,428,000.00
	Хоол,хүнс	94,471,054.00	102,927,051.00
	Нормын хувцас	-	1,495,000.00
	<u>Эд хогшил, урсгал засварын зардал</u>	<u>6,433,600.00</u>	<u>11,903,713.00</u>
	Багаж техник хэрэгсэл	1,369,000.00	1,307,290.00
	Тавилга	-	1,744,900.00
	Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл	-	1,450,000.00
	Урсгал засвар	5,064,600.00	7,401,523.00
	<u>Томилолт зочины зардал</u>	<u>-</u>	<u>1,638,000.00</u>
	Дотоод томилолт	-	1,638,000.00
	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХураамж</u>	<u>24,529,016.00</u>	<u>23,944,900.00</u>
	Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээ	1,000,000.00	1,200,000.00
	Даатгалын үйлчилгээ	229,100.00	350,000.00
	Мэдээлэл сурталчилгааны зардал	4,911,160.00	
	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	-	80,000.00
	Тээврийн хэрэгсэлийн татвар	243,300.00	180,600.00
	Газрын төлбөр	167,200.00	247,000.00

	Төлбөр хураамж болон бусад зардал	15,422,256.00	17,909,400.00
	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	1,000,000.00
	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,556,000.00	2,977,900.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	40,083,990.00	44,127,021.00
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	23,104,800.00	
	Бараа үйлчилгээний бусад зардал	16,979,190.00	44,127,021.00
	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал	50,588,400.00	30,287,520.00
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	44,268,700.00	
	Тэтгэвэрт гарахад тэтгэмж	6,319,700.00	30,287,520.00
	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>	<u>78,273,879.94</u>	<u>159,995,368.00</u>
	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,942,879.94	159,995,368.00
	Өглөг	1,331,000.00	-
	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ / 3=1-2 /</u>	<u>- 31,647,000.00</u>	<u>4,152,200.00</u>
	<u>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН / 5 /</u>	<u>-</u>	<u>-</u>
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,306,200.00	4,142,100.00
	<u>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ / 6=4-5 /</u>	<u>- 13,306,200.00</u>	<u>- 4,142,100.00</u>
	<u>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</u>	<u>- 44,953,200.00</u>	<u>10,100.00</u>
	<u>Мөнгө эхний үлдэгдэл</u>	<u>44,953,200.00</u>	<u>-</u>
	<u>Мөнгө эцсийн үлдэгдэл</u>	<u>- 0.00</u>	<u>10,100.00</u>

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн
	2014 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	2,751,097,413.00	215,438,378.00	- 419,965,111.00	2,546,570,680.00
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ				-
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
	Тайлант үеийн үр дүн				-
					-
	<u>2015 оны 12-р сарын 31- нээр</u>	<u>2,751,097,413.00</u>	<u>215,438,378.00</u>	<u>- 419,965,111.00</u>	<u>2,546,570,680.00</u>
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,001,334.00	1,001,334.00
	Дахин үнэлгээний нэмэгдэл				-
	Өглөг				-
	Өнгөрсөн үеийн үр дүн				-
	Тайлант үеийн үр дүн			10,870,746,002.31	10,870,746,002.31
	<u>2016 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл</u>	<u>2,751,097,413.00</u>	<u>215,438,378.00</u>	<u>10,451,782,225.31</u>	<u>13,418,318,016.31</u>

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2016/01/01 - 2016/12/31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,768,761,900	4,739,960,865	28,801,035	99%
	УРСГАЛ ЗАРДАЛ	4,734,554,300	4,549,677,977	184,876,323	96%
	Ажиллагчилтай холбогдсон зардал	730,068,600	676,296,219	53,772,381	93%
	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	651,847,000	604,123,312	47,723,688	93%
	Үндсэн цалин	502,912,800	473,376,342	29,536,458	94%
	Хоол унааны хөнгөлөлт	60,214,000	52,845,866	7,368,134	88%
	Урамшуулал	88,720,200	77,901,104	10,819,096	88%
	Ажил олгогчоос төлөх шимтгэл	78,221,600	72,172,907	6,048,693	92%
	Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	45,629,300	72,172,907	- 26,543,607	158%
	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,214,800		5,214,800	0%
	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	13,036,900		13,036,900	0%
	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,303,700		1,303,700	0%
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	13,036,900		13,036,900	0%
	Бараа үйлчилгээний урсгал зардал	4,004,485,700	3,873,381,758	131,103,942	97%
	Байр ашиглалттай холбоотой зардал	207,599,400	63,388,746	144,210,654	31%
	Гэрэл цахилгаан	129,372,900	29,376,628	99,996,272	23%
	Түлш халаалт	39,576,500	21,137,068	18,439,432	53%
	Цэвэр бохир ус	38,650,000	12,875,050	25,774,950	33%
	Хангамж бараа материалын зардал	18,830,900	19,387,227	- 556,327	103%
	Бичиг хэрэг	1,520,100	1,459,800	60,300	96%
	Тээвэр шатахуун	3,971,000	5,550,900	- 1,579,900	140%
	Шуудан холбоо интернет	1,828,100	1,439,567	388,533	79%
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгал, ариутгал	11,140,600	10,629,960	510,640	95%
	БҮТЭЗүйлс	371,100	307,000	64,100	83%
	Нормативт зардал	3,696,478,400	3,705,559,951	- 9,081,551	100%
	Эм,эмнэлгийн хэрэгсэл	3,599,978,400	3,601,137,900	- 1,159,500	100%
	Хоол,хүнс	95,000,000	102,927,051	- 7,927,051	108%
	Нормын хувцас	1,500,000	1,495,000	5,000	100%
	Эд хогшил, урсгал засварын зардал	11,787,200	14,002,613	- 2,215,413	119%
	Багаж техник хэрэгсэл	3,750,000	3,406,190	343,810	91%
	Тавилга	3,886,500	1,744,900	2,141,600	45%
	Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл	1,450,000	1,450,000	-	100%
	Урсгал засвар	2,700,700	7,401,523	- 4,700,823	274%
	Томилолт зочины зардал	823,500	1,638,000	- 814,500	199%
	Дотоод томилолт	823,500	1,638,000	- 814,500	199%
	Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ төлбөр	24,466,300	23,944,900	521,400	98%
	Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээ	1,200,000	1,200,000	-	100%
	Даатгалын үйлчилгээ	350,000	350,000	-	100%
	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,098,100	2,977,900	120,200	96%
	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	85,000	80,000	5,000	94%
	Тээврийн хэрэгсэлийн татвар	400,000	180,600	219,400	45%
	Газрын төлбөр	250,000	247,000	3,000	99%
	Төлбөр хураамж болон бусад зардал	1,000,000	1,000,000	-	100%
	Бусад зардал	18,083,200	17,909,400	173,800	99%
	Бараа үйлчилгээний бусад зардал	44,500,000	45,460,321	- 960,321	102%

Хичээл үйлдвэрлэлийн дадлага				-	
Бараа үйлчилгээний бусад зардал	44,500,000	45,460,321	- 960,321	102%	
<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>	<u>34,207,600</u>	<u>30,287,520</u>	<u>3,920,080</u>	<u>89%</u>	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал	-	-	-		
Тэтгэвэрт гарахад тэтгэмж	34,207,600	30,287,520	3,920,080	89%	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-		-		
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,764,841,900	4,739,970,965	24,870,935	99%	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,357,390,000	1,309,953,765	47,436,235	97%	
Бусад орлого		4,350,450	- 4,350,450		
Төсвөөс санхүүжих	3,407,451,900	3,407,451,900	-	100%	
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		14,832,566	- 14,832,566		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт		3,382,284	- 3,382,284		
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,100			
<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>		159,995,368	- 159,995,368		
Төвлөрүүлэх шилжүүлэг		159,995,368	- 159,995,368		
Өглөг			-		
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ / 3=1-2 /</u>		10,100			
Мөнгөн хөрөнгө 2016.12.31-ны үлдэгдэл	-	10,100			
Харилцахын үлдэгдэл					
Байгууллагын тоо	30				
Ажиллагчид бүгд	30	25			
Удирдах ажилтан	10	10			
Гүйцэтгэх ажилтан	10	10			
Үйлчлэх	10	5			